НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Дотоод албан хэрэгцээнд

ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

нэг. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар буюу **44-р долоо хоногт** нийт Нийслэлийн 8 дүүрэг, 12 аймагт **1682** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.

1260
Эмнэлэгийн тусламж авч буцсан

392
Хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан

23
(Сэжигтэй 4)
Нас барсан



Эр	Эм
789 (47%)	893 (53%)

Хүүхэд (0-17 нас) **700**

Насанд хүрэгч (18< нас) **982**

Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1682 тохиолдлын 95% /1590/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 5% /89/ нь орон нутагт (Архангай /1/, Баян-Өлгий /13/, Баянхонгор /3/, Булган /1/, Говь-Алтай /11/, Дорноговь /3/, Дорнод /4/, Орхон /4/, Өвөрхангай /12/, Өмнөговь /3/, Сэлэнгэ /1/, Төв /25/, Ховд /1/, Хөвсгөл /8/), тодорхойгүй /2/ бүртгэгдсэн байна. Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **477** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.



44 ДҮГЭЭР ДОЛОО ХОНОГТ

(2026.10.25 – 2026.10.31)

2026 оны дөчин дөрөвдүгээр долоо хоногт угаарын хийн хордлого **70** тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 27.3 хувиар, 5 жилийн дунджаас 4.48 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **1-44-р долоо хоногт** нийт **1568** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.

719	834	14	ЭМ	ЭР
Эмнэлэгийн тусламж авч буцсан	Хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан	Нас барсан	774 (49%)	793 (51%)



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 насны иргэд хамгийн их хордлогод өртөж байна.

2026 оны **дөчин дөрөвдүгээр долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **56** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 75.0 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 186 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (44-р долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	13	28	41
2	Эмийн хордлого	5	10	15
Нийт		**18**	**38**	**56**

Нийт 56 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 15 (27%) нь эмийн хордлого, 41 (73%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 38 (68%) тохиолдол, санаатай хордлого 18 (32%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

-o0o-